

Ч.Өлзийсайхан

Улс төр судлалын
тэнхимийн багш

1960-ААД ОНЫ ҮЕИЙН МОНГОЛЫН НИЙГЭМ ДЭХ УЛС ТӨРИЙН ЭЛИТҮҮД

Оршил: 1980-аад оны дунд үеэс нийгмийн сэтгэлгээнд үндсэн өөрчлөлт гарсантай уялдуулан улс төр судлалын хүрээнд ихээхэн дэвшил гарч олон арван бүтээл туурвил гарсан билээ. Гэвч энэ судалгаануудад орхигдож байсан, одоо ч дорвитой судалгаа хийгдэхгүй байгаа нэг сэдэв бол монголын улс төрийн элитүүдийн асуудал юм. Төрийн зүтгэлтнүүдийн талаар намтарчилсан зарим нэг бүтээл, тэдний дурсамж зэрэг цөөн тооны ном байгааг эс тооцвол тэдний үйл ажиллагаа, зөрчил тэмцэл, нөхцөл байдлын уялдаа холбоо зэргийг нарийвчлан судалсан судалгааны материал алга байна. Иймд монголын элитийн судалгаанд бага ч болов хувь нэмэр оруулах үүднээс энэ өгүүллийг бичсэн болно.

Түлхүүр үг: диктатур, номенклатурчид, эрх баригч ба эрх баригч бус элит, эрх мэдэл, үндсэн хууль, улс төрийн шаардлага, легитим чанар.

1990-ээд оноос өмнөх үеийн Монголын нийгмийн байгууллыг авч үзэхдээ бүх эрх мэдлийн төвд нь нам, намын удирдлагыг авч үзэж, онцлон тайлбарладаг билээ. Үндсэн хууль болон төрийн бусад баримт бичгүүд ч яг энэ үзэл санааны өнгө аясаар батлагдсан байдаг. Харин чухам яагаад нам, намын түшмэдүүд ард түмний нэрийн өмнөөс бүгдийг хийж байв гэдгийг бид өөрсдөө л 80-аад оны сүүлч, 90-ээд оны эхэн хүрч байж "ойлгож" тайлбарлаж эхэлсэн болохоос биш үүнийг нь практик амьдрал дээр хэрэгжихээс нь бүр өмнө, болсон үйл явдлыг хараад л бичиж байгаа юм шиг оновчтойгоор урьдчилан таамаглаж бичсэн алдартай эрдэмтэд цөөнгүй байдаг ажээ. Жишээлбэл, Германы улс төр судлаач, социологич Роберт Михельс "Ардчиллын нөхцөл дэх улс төрийн намын социологи" хэмээх бүтээлдээ "Нэг хүний диктатур нь өөрийн үр дагавраараа олигархи бүлэглэлийн дарангуйллаас огт ялгаагүй юм. Гэхдээ "диктатур" гэсэн ойлголт нь "ардчиллын" эсрэг ойлголт. Хоёрдугаарийн нэрээр нэгдүгээрхийг ашиглах явдал нь дайн бол энх тайвныг хамгаалах хамгийн шилдэг арга, архи нь архинаас гаргах эм гэж хэлж байгаагаас огт ялгаагүй... Хүн төрөлхтний олонхи хэзээ ч өөрсдийгөө удирдах чадваргүй. Тэр ч байтугай сэтгэл дундуур олон түмэн ноёрхогч ангийг засаглалаас нь зайлуулж чадлаа ч гэсэн тэр олон түмний дотор нь шинэ, зохион байгуулалттай цөөнх зайлшгүй

гарч ирж, өөртөө ноёрхогч ангийн үүргийг авах болно"¹ гэжээ. Энд Р.Михельс одоогоос 90 гаруй жилийн өмнө ард түмний нэрээр гарч ирсэн тэр улс төрийн байгуулал чинь ялгаагүй цөөнхийн ноёрхолыг хэрэгжүүлэх болно гэдгийг маш тодорхой хэлж байжээ. Улс төрийн сэтгэлгээний түүхэнд иймэрхүү байдлаар асуудлыг тавьж байсан эрдэмтэд олон бий.

1980-аад оны сүүлч хүртэл "элит" гэдэг нэр томъёог манай нийгэм улс төрийн сэтгэлгээнд хэрэглэж байгаагүй. Янз бүрийн нэвтэрхий толиудад дарлагч ангийг зөвтгөсөн хөрөнгөтний үзэл суртал гэсэн утгатай тайлбарлууд байдаг байсныг бид одоо ч харж болно. Чухам яагаад үүнийг үгүйсгэх болов гэдэг нь бас тодорхой учир шалтгаантай. Элит судлалын сонгодог төлөөлөгчид ч, хожуу үеийн судлаачид ч элит бол нийгмийн хамгийн шилдэг сайн зохион байгуулалттай, баялаг, боловсрол, оюун санааны хувьд олон түмнээс давуу талтай, түүнийгээ ашиглаж ноёрхлоо хэрэгжүүлж байдаг гэж үзсээр ирсэн. Эндээс дарлагч, мөлжигч, хөрөнгөтөн анги гэж марксизмд томъёологдсон нийгмийн хэсгийг бусдаас илүү, шилэгдмэл гэж хүлээн зөвшөөрөхөд хүрэх, ингэснээр ажилчин ангийн манлайлалын тухай асуудал нь утга учраа алдах байсан тул энэ нь хаалттай, судлагддаггүй асуудал байсан болов уу.

Гэхдээ тоталитари дэглэмийн үеийн удирдагч анги, хэдийгээр өөрсдийгөө ард түмний боол, тэдний төлөө бүхнээ зориулагчид гэж нотлохыг оролдож байсан ч уг давхрага маань ялгаагүй л хүний нийгмийн хөгжлийн тэр жам ёсноос гажаагүй бас л элит давхаргын шинжийг шингээсэн л байсан билээ. Гэхдээ улс төрийн системийнхээ өвөрмөц онцлогоос болоод тэдний үүргээ гүйцэтгэх арга барил, сонгон шалгаруулах механизм нь өөрийн гэсэн онцлогтой. Жишээлбэл, номенклатурчид өөрөө дотроо нарийн иерархитай, МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга бол намдаа ч, төрдөө ч нэг номерийн эрх мэдэлтэн байна. Дараа нь Улс Төрийн Товчооны гишүүд, Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга нар, БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчид, Сайд нарын Зөвлөлийн гишүүд, ТХ-ны хэлтсийн эрхлэгчид, орлогч эрхлэгчид гэх мэтчилэн эрэмбэлэгдэнэ. Аймаг хотын эрх мэдэлтнүүд ч намын удирдлага нь нэгдүгээрт, АДХГЗ-ны дарга нар нь хэдийгээр дүйцүүлж болох өндөр албан тушаал боловч намын удирдлагатайгаа харьцуулахад хоёрдугаарт тавигдана. Намын үзэл суртлыг дэлгэрүүлж, боловсон хүчнээр хангах зориготой МХЗЭ, МҮЭ-ийн удирдлага ч одоогийн залуучуудын болон үйлдвэрчний эвлэлийн ямар нэг байгууллагын удирдлагатай харьцуулшгүй их эрх мэдэлтэй, намын нөөц хүч, залуу халаа гэсэн утгаараа ямарч шүүмжлэлээс ангид байсан билээ. Дээрх дээд албан тушаалд хүрэхийн тулд хамгийн энгийнээс авахуулаад маш олон шат дамжлагыг дамжих ёстой бөгөөд энэ ахиц дэвшилд хамгийн гол нөлөөлөх хүчин зүйл нь дээд удирдлагын үнэлгээ байна.

¹ Р.Т.Мухаев. Политология. Хрестоматия. М., 2000. стр 299-300

Номенклатурчид хичнээн ард түмний нэг, тэдний төлөө өөрсдийгөө золиослогч гэж өөрсдийгөө нэрлэлээ ч, нийгэмд эзэлж байшаа давуу байдлаа ашиглан өөрсдөдөө эрх ямбыг бий болгосоор байжээ. Тэдний амралт, хоол ундны асуудлыг ч тусгай тогтоол шийдвэрээр зохицуулж байсан ба эдгээрээс улбаатай тусгай хангамж, эмнэлэг, эд хогшил, гадаад дотоод амралт, орон сууц гэх мэт ихээхэн давуу нөхцөл байдлаар хангагдаж байв. Гэхдээ тэд хэдийгээр илүү эрх ямбатай байсан ч аль ч нийгмийн элитүүдэд байдаг мэдлэг боловсрол, эрдэм чадлын давуу тал гарцаагүй байсан юм. Улс орныг удирдахад гарцаагүй чухал боловсролын тухай асуудал нь яг жинхэнэ ёсоор улс төрийн элитүүдэд л өндрөөр тавигдаж байсан шаардлага байсан болохоос биш, тэднийг нуун далдлах ёстой, ёс төдий үүрэг гүйцэтгэгч депутат, төлөөлөгчдөд төдийлөн хамааралгүй юм. 1960 оны Үндсэн хуульд БНМАУ-ын улс төрийн үндэс нь бүх шатны Ардын Депутатуудын Хурал гээд, АИХ нь хууль тогтоох эрхтэй, төрийн эрх бүхий дээд байгууллага, АИХ-ын чуулганы чөлөө цагт АИХ-ын тэргүүлэгчид төрийн эрх барих дээд байгууллага байхаар, гүйцэтгэн захирах дээд байгууллага нь Сайд нарын Зөвлөл байхаар хуульчлан заасан байдаг. Энд улс төрийн элитэд байх тэр давуу чанарууд АИХ-ын тэргүүлэгчид, СнЗ-ийн гишүүд гэх мэт хүмүүст байхаас бус, дээрх хуулиндаа хамгийн даад гэж нэрлэгдээд байгааг АИХ-ын депутат, гишүүдэд байх албагүй. Тэд эрх мэдэлтэн гэхээсээ урамшуулал авсан хүмүүс гэж дүгнэгдэх нь илүү оновчтой. Гэхдээ энд Паретогийн “Өөрийн үйл ажиллагааны хүрээнд илүү өндөр индекс авсан хүмүүсийг сонгогдмол элит гэж нэрлэе... Нийгмийг удирдахад мэдэгдэхүйц үүрэг гүйцэтгэж байгааг нь эрх баригч элит, үлдсэнийг нь эрх баригч бус элит гэнэ”¹ гэсэн байдгаас үндэслэн тайлбарлах гэж үзвэл дээрх депутат, гишүүд маань хэлбэрийн хувьд эрх баригч элит, агуулгын хувьд эрх баригч бус элитүүд юм.

Элитүүдийн төлөвшилт нь социализмын үед урсгалаар байв уу, эсвэл төрөөс зохицуулж байв уу гэсэн асуулт тавигдаж байна. Ер нь аль ч үед элитийн шалгаруулалт нь тодорхой эмх цэгцийг агуулж байдаг ч тохиолдлын чанартайгаар улс төрийн элитэд орж ирж болохыг эртний түүх судраас ч олж харж болно. Жишээ нь: Тэмүүжин, Боорчи нарын нөхөрлөсөн түүх², мөн Чингис хаан Зэвтэй нөхөрлөсөн түүх³ зэргийг дурдаж болно. 1964 оны VI бүгд хурал дээр Б.Дэижд “нөхөр Цэдэнбалыг намтай адил үзнэ. Цэдэнбал бол нам гэсэн үг. Нам Цэдэнбал хоёрыг салгаж болохгүй. Цэдэнбалыг дайрч байгаа явдал бол манай намыг дайрч байгаа явдал мөн” гэж ярьж байхад Ю.Цэдэнбал бичиж байсан юмаа орхиод шимтэн харж байлаа. Нямбуу тэгэхэд тэмдэглэлийнхээ дэвтэртээ “Энэ хүн

¹ Р.Т.Мухаев. Политология. Хрестоматия. М., 2000. стр 239

² Монголын нууц товчоо. Ред Ш.Гаадамба. УБ., 1990. х 52-54.

³ Мөн тэнд. Х 93

эзэндээ танигдаж, идэх хоолтойгоо боллоо”¹ гэж тэмдэглэжээ. Энэ мэтчилэн зарим нэг тохиолдлын зүйл дээд түвшний эрх барих бүлэгт орж ирэхэд нөлөөлдөг байхыг үгүйсгэхгүй. Гэхдээ л ер нь элит төлөвшиж байгаа ерөнхий механизмыг харвал тэр нь огтхон ч урсгалаар явагдахгүй, харин ч төр, дээд эрх баригчдын нягт нямбай зохицуулалтаар явагддаг болохыг олон жишээгээр харуулж болно. 1960-аад оны үеийн маргаантай асуудлууд нь элитийг хатуу чанд гараар зохицуулж байсны хамгийн тодорхой жишээ юм.

МАХН-ын ТХ-ны VI бүгд хурлын тогтоолд (1964) “МАХН-ын ТХ-ны гишүүн бөгөөд Сангийн аж ахуйг удирдах газрын дарга агсан Ц.Лоохууз, Өмнөговь аймгийн Намын Хорооны нарийн бичгийн дарга асан Б.Нямбуу, БНМАУ-ын Статистикийн Төв Газрын дарга Б.Сүрмаажав нар МАХН-ын Төв Хорооны урьдах бүгд хурлууд дээр удаа дараа гаргасан эрүүл бус үзлээ орхиогүйгээр үл барам, алдаатай бодлогоо улам гүнзгийрүүлж, сүүлийн үед хагарал гаргах явуулга хийх замд шууд оржээ...”

Лоохууз, Нямбуу, Сүрмаажав нараас намын эсрэг шугам баримталж хагарал гаргах явуулга хийснийг НТХ-ны гишүүд, орлогч гишүүд гүнээ жигшин нэгэн дуугаар эрс буруушааж, хэт хувьсгалч үгээр халхавч хийсэн үл бүтэх явдлыг бүрэн илрүүлэв. Тэднээс нам, түүний ТХ-ны марксч-ленинч шугам, практик үйл ажиллагааг ямар ч ул үндэсгүй дайрч гүтгэснийг бүгд хурал хөдлөшгүй баримтаар илрүүлэн няцааж пролетарийн интернационализмын зарчимд гуйвшгүй үнэнч байгаагаа тод харууллаа...

...Улс төрийн сонор сэрэмжээ байнга дээшлүүлж, намын эгнээний нэгдэлд хор учруулагч аливаа явуулгыг илчлэн тас цохихыг...МАХН-ын бүх байгууллага, гишүүдэд үүрэг болгосугай” гэсэн байдаг нь намын гишүүдэд, ялангуяа улс төрийн элитүүдэд ямархуу шаардлага тавигдах болсныг тодорхой харуулдаг. Хэрвээ элитийн бүрэлдэхүүнд орж байхыг хүсч байгаа л бол нэр төр, үзэл суртлын хувьд өөгүй цэвэр, намын хувьд гуйвалтгүй үнэнч, удирдах дээд хэсэгтээ дээд зэргээр таалагдах ёстой болж байв. Ер нь үзэл сурталдаа үнэнч байх гэдэг шаардлага нь нөгөө нэг үзүүрээс нь харвал дээд түвшний элитүүдийн талжсих процесс, өөрөөр хэлбэл тэдний байр сууриа хадгалахад нь халхавч болох, шүүмжлэлээс ангид байх гол нөхцөл нь байсан гэхэд хилсдэхгүй.

1964-1-26-ны өдрийн МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга нарын зөвлөлгөөний тогтоолд “...Намын Төв Хорооны намын байгууллагын хэлтсийн зохион байгуулагч Очирын Нямааг дээрх бүлгийн ажиллагаанд оролцож байсан тухай НТХ-ны бүгд хурал дээр шүүмжлэл гарсан тул түүнийг үүрэгт ажлаас нь халсугай. О.Нямаатай холбогдсон асуудлыг НХШХ-нд шилжүүлэн шалгуулахаар тогтоосугай” гэжээ. Энд зөвхөн нэг хүн нь нөгөө хүнээ шүүмжлэх нь тэр хүний хувь заяаг шийдчихсэн байгаа нь харагдаж

¹ Г.Аким. хэлмэгдсэн заяа. УБ., 1999. х 28

байна. Энэ мэтчилэн тоталитари дэглэмийн үед элитийн төлөвшилт нь төрийн бодлогоор, гэхдээ төрийн хатуу бодлогоор зохицуулагдаж байсан нь харагддаг. Гэхдээ энд Людовик XIV-ийн хэлсэнчлэн "Төр гэдэг чинь би" гэсэн алдартай үг нь юм уу, дээр дурдсанчлан Дэжидийн хэлсэн шиг "Цэдэнбал гэдэг чинь нам гэсэн үг" гэдэг шиг нэг юм уу, цөөн хэдэн хүний дарангуйллаар асуудал шийдэгдэж байсан болох нь ойлгомжтой юм.

1960-аад оны нам төрийн эсрэг гэх энэ үйл явдал нь уг нь төрийн бодлогыг үндсээр нь өөрчлөх бодлого агуулаагүй юм. Харин намын хүнд суртлыг арилгах, ардчиллыг хөгжүүлэх, боловсон хүчний бодлогод шударга зарчим тогтоох, ард түмний үндэсний соёлын өв, зан заншлыг сэргээн хөгжүүлэх, хойш хөршийн эрхшээлд хэтэрхий их орж байгаа хандлагыг зогсоох зэрэг шаардлагууд тавьсан байлаа. Тэдний буруутай болж хэлмэгдэх хамгийн гол шалтгаан нь тэд өөрсдөөсөө хавьгүй их эрх мэдлийг гартаа оруулсан нэг номерийн хүнийхээ эсрэг чиглэсэн үйл ажиллагаа явуулсанд байгаа юм. Ю.Цэдэнбалд ч энэ үеийн үйл явдал хэзээ ч мартагдашгүй сургамж өгсөн бөгөөд үүнээс хойшхи үед өөрийгөө өө сэвгүй хүн, ард түмний шалгарсан ганц хүү, Монгол-Зөвлөлтийн найрамдлын бэлэг тэмдэг гэж үргэлжийн магтаал, сайшаалаар булуулж, ямар нэг өчүүхэн ч гэсэн эргэлзсэн үзэл санааг нам, ард түмэн, найрамдал, пролетарийн интернационализм гэсэн халхавчаар тас цохиж, өөрөө нөмөрт нь халдашгүй дархан болж үлдсэн билээ.

Ер нь 1960-аад энэ хэлмэгдүүлэлт нь 1930-аад оны хэлмэгдүүлэлтээс зөвхөн харгис эрүү шүүж, буудан алдаг аргаас нь л ялгаатай болохоос бус хүнийэрх, эрх чөлөөг асар бүдүүлгээр зөрчиж байснаараа нэг их ялгараад байх зүйл байгаагүй. 20-30 жил тасралтгүй мөрдөх, утгсыг нь чагнах, өвлийн хүйтэнд хамгийн хол хязгаар руу цөлөх, орон байрнаас нь хөөж гаргах, хамгийн хүнд хүчир ажил хийлгэх, үр хүүхдийг нь сургууль, ажлаас нь хөөх зэргээр амьдын там эдлүүлж байжээ. Тэднийг хардаж сэрдсэн анхны сэжим нь хүн гайхмаар өчүүхэн зүйлээс эхтэй байх нь олонтоо. Энэ хэдэн хүнийг хэлмэгдүүлснээрээ Ю.Цэдэнбал өөрийн нь эсрэг тэмцэх нь хичнээн эмгэнэлтэй төгсгөлтэй болохыг бүгдэд хатуу ойлгуулж өгсөн юм.

1960-аад оны үеийн шинэлэг, бодит байдлыг үнэн зөвөөр харах гэсэн, улс орныхоо хөгжлийг түргэтгэх арга зам хайсан шилдэг хүмүүсээ хэлмэгдүүлсэн нь энэ үед монгол оронд тоталитари улс төрийн дэглэм бүрэн утгаараа цэцэглэн хөгжсөн байсныг тодорхой харуулдаг. Өөрөөр хэлбэл, энэ дэглэмийг тодорхойлдог гол шинжүүд болох нэг хатуу зорилгод нийгмийн нийт гишүүдийг уриалан дуудсан үзэл суртал, нэг лидер, нэг намын ноёрхол, нам нь төрийн үүргийг гүйцэтгэх байдал, цагдаагийн хатуу хяналт, эдийн засгийн төвлөрсөн хяналт зэрэг нь бүгд системчлэгдэж, улс төрийн элит болох асуудал нь лидерийнхээ үзэмж, түүнд үнэнч байдлаар хэмжигдэх болсон. Тоталитаризмын үеийн зорилго, төлөвлөгөө, үзэл санаа нь хувь

хүний эрх, эрх чөлөөг, туйлын ихээр боогдуулж цөөнхи дээрхи олонхийн дарангуйллаар, яг нарийндаа бол олонхийн дүрээр хаацайлагдсан эрх баригч цөөнхийн хязгааргүй дарангуйллаар хэлмэгдүүлэлт гэгч харгис үйл ажиллагаа явагдсан билээ.

1960-аад оны хэлмэгдүүлэлт нь Монгол улсын дотоодын төдийгүй гадаад олон улсын нөхцөл байдалтай нарийн уялдаа холбоотой явагджээ.

1953 онд Иосиф Вассарионович Сталин нас барж, ЗХУКН-ын ТХ-ны нэгдүгээр нарийн бичгийн даргаар Никита Сергеевич Хрущев сонгогдов. 1956 оны 2 сард ЗХУКН-ын XX их хурал хуралдаж, Сталиныг тахин шүтэж байсан явдал, түүний хор уршгийг даван туулах тухай асуудлыг авч хэлэлцэв. Мөн Зүүн Германд зах зээл нь зөвхөн ЗХУ руу чиглэсэн, бүтээгдэхүүн нь зөвхөн ЗХУ-д борлогддог, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн дутагдалтай, хүчээр хамтралжуулсан, эдийн засаг нь зогсонги байдалтай байгаа зэргийг эсэргүүцэн ажил хаялт болж, бослогын хэмжээнд хүрч, ЗХУ танк, цэрэг оруулж үймээнийг даржээ.

1956 оны зургаадугаар сард Польшийн Познань хотод ЗХУ-аас хараат байгааг болиулах, намыг ардчилах, католик сүм хийдийг чөлөөтэй болгох зэрэг шаардлага тавьсан ажил хаялт болж, бас л цэрэг зэвсгийн тусламжтайгаар ажил хаялтыг зогсоов.

1956 оны аравдугаар сард Унгарын нийслэл Будапештэд жагсаал цуглаан болж, ардчилал, ил тод байдлыг хөгжүүлэх, ЗХУ-аас бүрэн салж, тусгаар тогтнох, Варшавын гэрээнээс гарах, олон намын тогтолцоо бий болгох зэрэг шаардлага тавив. Энэ тэмцлийг дарахаар ЗХУ-ын танк, цэргийн хүч Будапештэд орж, босогчид чулуу, их буу, автоматаар зэвсэглэн мөргөлдөөн болж, ЗХУ-ын 600 орчим цэрэг, Унгарын 4000 орчим иргэд нас баржээ.

1950-аад оны дунд үеэс ЗХУ-БНХАУ, ЗХУ-Югаславын харилцаа эрс муудаж ирэв. Олон улсын хэмжээнд болж байсан эдгээр олон үйл явдлууд, өөрөөр хэлбэл, улс орныхоо удирдлагуудын явуулж байгаа гадаад, дотоод бодлогод шүүмжлэлтэй хандсан эсэргүүцэл тэмцэл нь монголын нийгэм улс төрийн зүтгэлтнүүдэд ч нөлөө үзүүлсний тодорхой жишээ дээрхи 60-аад оны гэгдэх шүүмжлэлт уур амьсгал, хэлмэгдүүлэлт байсан гэж үзэхээс өөр аргагүй юм. Эдгээр зүтгэлтнүүдийн тавьсан шаардлага нь бусад орнуудад тавигдсан шаардлагатай бараг л адилхан, тухайлбал намд ардчилал алга байна, боловсон хүчнийг сонгох сонголт муу, ард түмэн, эдийн засгийн онцлогоо мэдэхгүй Монгол улс ЗХУ руу хэтэрхий их ханарч байгааг болиулах, Хятадтай найрамдалт харилцаагаа сайжруулах, бусад оронтой худалдаа хийх зэрэг шаардлага тавьсан нь эрх баригч хүчний өмнө хэтэрхий хүчгүйдэн бут цохигджээ. Энэ үймээн самуун нь Ю.Цэдэнбал тэргүүтэй эрх баригчдад тодорхой хэмжээгээр ашигтай болсон гэхэд хилсдэхгүй. Учир нь эднийг ингэж хэлмэгдүүлснээр өөрсдийн эсрэг тэмцэгчдийг өчүүхэн ч гэсэн толгой өндийлгөх бололцоо олгохгүй

болгоомжтой болсон, хүчний байгууллагуудыг ч энэ чиглэлд нягт нямбай зохион байгуулж өгсөн, мөн Цэдэнбал ЗХУ-ын төлөөлөгчдөд өөрийн нь тухай шүүмжилсэн тухай асуудлыг дурдалгүй, харин Хятадын тухай тэдний үзэл бодлыг л тайлбарласнаараа тухайн үед Хятадын аюулаас асар их болгоомжилж байсан ЗХУ-ын хувьд хамгийн их найдаж болох хүн гэж өөрийгөө ойлгуулж чадсан билээ. Ингэснээрээ Монголын төрийн эрх барих элитүүдэд Орос улс, Коминтерн асар их нөлөө үзүүлж чаддагийн бас нэг нотолгоо болж, Ю.Цэдэнбал 40 гаруй жил тасралтгүй нам төрийн тэргүүнээ хадгалав. 40 гаруй жилийн дараа байраа тавьж, дараагийн удирдагч гарч ирэх үйл явдалд ч ЗХУ шийдвэрлэх нөлөө үзүүлсэн билээ.

1960-аад оны үйл явдлуудыг авч үзэхдээ хоёр сэргэлдөгч талуудын аль нь тухайн үед мөрдөгдөж байсан хууль, юуны өмнө Үндсэн хуулийг зөрчиж байсан юм бэ? гэсэн асуудал тавьж болох юм. 1960 оны Үндсэн хуульд заасан улс нийгмийг удирдах хэрэгт оролцох, төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус ажиллагаа, чирэгдэл, хүнд суртал гаргасан тухай төрийн эрх барих байгууллага болоод захиргааны аль ч байгууллагад өргөдөл гомдлоо амаар болон бичгээр өгөх эрх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, хурал цуглаан хийх зэрэг эрх нь тусгагдсан байдаг. Энэ утгаараа энэ үйл явдалд оролцогчид Үндсэн хуулиар олгогдсон эрхээ л эдэлсэн байдаг юм. Гэтэл энэ Үндсэн хуулийн 89 дүгээр зүйлд иргэдийн үндсэн үүргийг заахдаа социалист хэв журмыг дагаж, нийгмийн ёс дэглэмд харш аливаа үзэгдэлтэй идэвхтэй тэмцэх..., ЗХУ тэргүүтэй социалист лагерийн орнуудтай тогтоосон найрамдал, нэгдэлд хор хохирол учруулж болох элдэв үзэгдэлтэй шийдвэртэй тэмцэх..., дайснаас ямагт сэрэмжилж байх, социалист эх орноо социализмын дайснаас ариунаар хамгаалах зэрэг заалтууд оруулж өгсөн байдаг нь эрх баригчид ч иргэнийхээ үүргийг биелүүлсэн гэдгээр хаацайлж, зөвхөн өөрсдийн үйл ажиллагааг шүүмжилсэн явдлыг дарах бололцоо олгосон байдаг. Өөрөөр хэлбэл, сэргэлдөгч хоёр тал хоёулаа эрхээ эдэлж, үүргээ гүйцэтгэсэн сонин зөрчилтэй харьцаанд оржээ. Тэгэхээд 1960 оны Үндсэн хуульд заагдсан хүний эрхийн заалтууд нь уг хуулийн бусад заалтаараа няцаагдаж, ингэснээрээ эрх баригч ангид аль ч талаараа бодсон ашигтай болж дууссан билээ.

Өөр нэг анхаармаар асуудал нь тухайн үеийн эрх баригчид, тэдний засаглалын легитим шинж ямар түвшинд байв гэдэг асуудал юм. Хүний эрх, эрх чөлөөг зөрчдөгөөрөө, нийгмийн амьдралын бүхий л хүрээнд хяналт тогтоосноороо, эрх баригч элитүүд нь сөрөг элитүүдээ нухчин дардагаараа, төрийн үүргийг нэг нам гүйцэтгэх болсноороо, засаглалыг хэрэгжүүлэгчид, элитүүдийн хуульчлагдах байдал, легитим шинж доогуур баймаар. Үүнийг эрх баригчид хэрхэн зохицуулсан бол гэдэг сонирхолтой. Үүнд хариулахын тулд М.Веберийн уламжлалт, харизмат, хууль ёсны гэж ангилж байсан легитим чанарын алинд нь тухайн үеийн засаглал хамрагдаж

болохыг харья. Уламжлалт легитим шинж нь ёс заншил, эртнээс уламжилж ирсэн дэг журам хөдлөшгүй бат бэх гэж үзэх итгэл үнэмшил дээр тулгуурладаг. Тэгвэл социализмын үеийн төр нь хэдийгээр үе дамжин уламжлагдаагүй ч гэсэн харьцангуй урт удаан хугацааны туршид оршин тогтносоор ирсэн, иргэд нь энэ төр засгаа уламжлалт төртэй адилтгасан байдлаар хүлээн авч ойлгодог байснаар нь авч үзвэл энэ нь уламжлалт легитим чанарт нилээд дөхөж очмоор харагдаж байна.

Мөн удирдагчийгаа хамгийн авьяас чадвартай, бүхнийг мэдэгч болгон хүлээн авч, ямарч салбарын асуудлаар хэлсэн үг бүрийг нь хамгийн үнэн зөв, ганц шалгуур байдлаар хүлээн авч нийгэмд хүлээн дэлгэрүүлдэг байснаараа энэ нь харизмат легитим шинж бүхий засаглал байжээ гэж үзэж болмоор байдаг. Ер легитим шинжийн тухай М.Веберийн ангилал дээр нэмж өөр хэлбэрийг, жишээлбэл үзэл суртлын легитим шинж гэж байж болох юм гэж зарим судлаачид үзэж байна¹. Миний бодоход угаасаа үзэл суртал нь дээрхи гурван хэлбэрийн легитим шинжийг улам баталгаажуулж байдаг арга хэрэгсэл л юм. Тэр тусмаа харизмат хошуучлалын үед удирдагчийн онцгой авьяас чадварыг олон түмэнд итгүүлж, үнэмшүүлэхэд үзэл суртал өөрөө маш чухал үүргийг гүйцэтгэж байдаг. Иймээс үүнийг биеэ даасан нэг легитим байдлын хэлбэр гэж үзэх нь төдийлөн тохиромжгүй юм уу гэсэн эргэлзээ төрж байна. Шашин бол ард түмнийг мунхруулагч хар тамхи гэж бүх нийтээр сурталчилдаг байсан болохоор нам, төрийн удирдлагыг бурханчлан итгүүлэх нь утгагүй. Харин үзэл суртлын аргаар л хамгийн цэцэн мэргэн, авьяаслаг гарамгай гэж итгүүлэх нь хамгийн оновчтой байсан. Энэ утгаараа социализмын үеийн удирдагчид маань харизмат хэв шинжид нэлээд дөхөж очдог.

Гурав дахь хувилбар болох хууль ёсны легитим шинж нь тоталитори дэглэмийн үеийн эрх баригч элитийн хувьд илүү хялбар, зохицуулж болох, ард түмний нэрээр хийж болох зүйл байсан нь ойлгомжтой.

Энэ бүхнээс дүгнэн үзэхэд 1990-ээд оноос өмнөх засаглал нь М.Веберийн томъёолсон легитим шинжүүдийг аль алиныг нь хослуулсан санагдаж байна. Энэ нөхцөл байдал нь тэднийг сөрөг хүчнээ нухчин дарах, байр сууриа бэхжүүлэх өөрсдийн хүсэл бодлыг ямар нэг хяналтгүйгээр хэрэгжүүлэх бодит бололцоо олгож байжээ.

1960-аад оны үеийн нам, төрийн эсрэг гэх хэрэг, түүний шийдсэн байдалд тоталитари дэглэмийн дарангуйлагч тогтолцоог улам бататгасан, нийгэмд айдас, болгоомжлолыг улам их болгосон үйл явдал болж дууссан билээ.

Эцэст нь хэлэхэд зөвхөн 60-аад оны үеийн төдийгүй, монголын нийгмийн бүхий л үеийн улс төрийн элитүүдийн асуудал нь дорвитой судалгааг шаардаж байгаа тул эрдэмтэн, судлаачид

¹ Улс төрийн шинжлэх ухаан. Ред Ц.Ганболд. УБ., 2001. х 98

анхаарлаа хандуулж, өөрсдийн хувь нэмрээ оруулаасай гэж хүсч байна.

Resume

The author described in the article about political elites' hierarchy in Mongolia, all inclusive meeting of the Congress of People's Deputy members' competence, structure and composition, and how general elite requirements had been put towards them and etc.

Also the issues of cause for opposition force defeats, external and internal circumstances in the country, the relation between state and citizenries are mentioned in it. The author then explain the issue, which is not paid attention by our researchers nowadays, as well as how human rights are violated in relevant constitution of the mentioned time, which of the confronting parties has broken the constitutional articles and the level of legitimacy of the ruling leaders.

Ном зүй:

1. Аким Г. Хэлмэгдсэн заяа. УБ.,1999
2. Баярхүү Д. Олон улсын харилцаа ХХ зуунд. УБ.,1994
3. БНМАУ-ын Үндсэн Хууль. УБ.,1960
4. Гүндсамбуу Х. Монголын нийгмийн давхраажилт: хөгжил, хандлага. УБ.,2002
5. Ичинноров С. Түүхийн үнэний мөрөөр. УБ.,2001
6. МАХН-ын ТХ-ны VI бүгд хурлын материал. УБ., 2001
7. Мухаев Т. Политологя. Хрестоматия. М.,2000
8. Монголын нууц товчоо. УБ.,1990. ред Ш.Гаадамба
9. Отгонжаргал С. ХХ зууны Монголын түүхийг шинээр эргэн харахуй 1921-1990. УБ.,2003
10. Содном Д. Амьдрал, бодол. УБ.,2003
11. Улс төрийн шинжлэх ухаан. УБ.,2001. ред Ц.Ганболд
12. Түүх-баримт. УБ.,1994